



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2012 оны 04 сарын 02 өдөр

Дугаар 102

Улаанбаатар хот

“Эрүүл мэндийн зарим мэргэжлээр
төгсөгчид тавигдах шаардлага батлах тухай

“Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг 2010-2014 онд хөгжүүлэх бодлого”-ыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Хүний их эмч мэргэжлээр төгсөгчид тавигдах шаардлагыг нэгдүгээр, Нийгмийн эрүүл мэндийн мэргэжлээр төгсөгчид тавигдах шаардлагыг хоёрдугаар, Нүүр амны их эмч мэргэжлээр төгсөгчид тавигдах шаардлагыг гуравдугаар, Уламжлалт анагаахын их эмч мэргэжлээр төгсөгчид тавигдах шаардлагыг дөрөвдүгээр, Эм зүйч мэргэжлээр төгсөгчид тавигдах шаардлагыг тавдугаар, Бакалаврын зэрэгтэй сувилагчид тавигдах шаардлагыг зургаадугаар, Дипломын зэрэгтэй сувилагчид тавигдах шаардлагыг долоодугаар, Туслах сувилагч мэргэжлээр төгсөгчид тавигдах шаардлагыг наймдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тушаалын хавсралтаар батлагдсан шаардлагыг анагаах ухаан, нийгмийн эрүүл мэнд, уламжлалт анагаах ухаан, нүүр ам судлал, эм зүй, сувилахуйн мэргэжлийн боловсролын стандартад тусган оруулсугай.

3. Тушаалыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг Төрийн захиргааны удирдлагын газар (Б.Баярт)-т даалгасугай.

САЙД



Н.ХҮРЭЛБААТАР

“Хүний их эмч” мэргэжлээр бакалавр
зэрэгтэй төгсөгчид тавигдах шаардлага

1. Мэргэжлийн нэр: Хүний их эмч
2. Мэргэжлийн индекс: D720300
3. Мэргэжлийн тодорхойлолт, тавигдах шаардлага

3.1 “Хүний их эмч” мэргэжлийн тодорхойлолт:

Анагаах ухааны бакалаврын боловсрол эзэмшсэн их эмч нь хувь хүн, гэр бүл, хамт олонд зонхилон тохиолдох өвчин эмгэгийг оношлох, эмчлэх, сэргээн засах, өвчний төгсгөлийн шатанд орсон өвчтөнд хөнгөвчлөх тусламж үйлчилгээ үзүүлэх болон аливаа өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээг гардан зохион байгуулах, биечлэн хэрэгжүүлэхэд шаардагдах мэдлэг, чадвар, хандлага эзэмшсэн мэргэжилтэн байна.

Төгсөгч нь онолын ба практикийн чиглэлээр судалгаа шинжилгээний ажил хийж болох ба цаашдаа төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалт, магистрантур, докторантурт суралцах эрхээр хангагдсан байна.

3.2 “Хүний их” эмч мэргэжлээр төгсөгчийн бэлтгэлд тавигдах нийтлэг шаардлага. Үүнд:

3.2.1 Анагаах ухааны үндсэн салбар шинжлэх ухааны суурь онол, арга зүйг судалж, ойлгож мэдсэн, тэр хүрээнд хүн амын эрүүл мэндийг сахин хамгаалах үндсэн арга, зарчмуудыг үйл ажиллагаандаа хэрэглэж чаддаг байх;

3.2.2 Хүн амын эрүүл мэндтэй холбоотой аливаа асуудалд мэргэжлийн үүднээс бодитой хандаж, тулгамдаж буй асуудлыг шинжлэх ухаанчаар задлан шинжилж, үйл ажиллагаандаа шинжлэх ухааны үндэслэлтэй аргуудыг хэрэглэж чаддаг байх;

3.2.3 Байгаль, нийгэм, хүмүүсийн хоорондын харилцааг зохицуулдаг ёс зүй, хууль, эрх зүйн хэм хэмжээг мэддэг, сахидаг, энэ чиглэлээр тавигдах шаардлагуудыг ёсчлон биелүүлдэг, энэрэнгүй сэтгэлтэй байх;

3.2.4 Эрүүл аж төрөх ёсны талаар шинжлэх ухааны үндэслэл бүхий мэдлэгтэй байж, өөрийн бие бялдар, оюун санааг хөгжүүлэх чадвар, хандлага, дадлыг эзэмшсэн, бусад хүмүүст үлгэр дууриал үзүүлдэг байх;

3.2.5 Өөрийн үйл ажиллагаанд бодитойгоор дүн шинжилгээ хийх чадвартай, орчин үеийн мэдээллийн технологийг ашиглан, шинэ мэдлэг, мэдээлэл олж авах, бүтээлчээр ашиглах болон биеэ даан тасралтгүй суралцах чадвартай байх;

3.2.6 Мэргэжлийн ажил үүргээ биелүүлэхтэй холбогдуулан өмнөө тавигдах зорилго, зорилтуудыг оновчтой тодорхойлж, тэдгээрт хүрэх үйл ажиллагааг зохистой төлөвлөж чаддаг, биелүүлэхийн төлөө тууштай тэмцдэг байх;

3.2.7 Эрүүл мэндийн байгууллагын удирдлага, зохион байгуулалт, санхүүгийн менежментийн талаар зохих түвшний мэдлэгтэй байж, түүнийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлдэг байх;

3.2.8 Багаар ажиллах чадвартай, харилцааны соёл бүхий ур чадвар эзэмшсэн, өөрийгөө хүнд ойлгуулах, бусдад зөвлөгөө өгөх ур чадвартай, үйлчлүүлэгчийн санал хүсэлтийг хүндэтгэн туслах, хариуцлага хүлээх чадвартай байх;

3.2.9 Англи хэлийг өдөр тутмын болон мэргэжлийн үйл ажиллагаандаа хэрэглэх;

3.2.10 Мэдээлэл зүй, компьютерийн хэрэглээний программуудыг хэрэглэх;

3.2.11 Ажиллаж буй байгууллагын дотоод дүрэм журам, цагийн хуваарийг чанд баримтлах;

3.2.12 Өөрийн ажлын байрны тодорхойлолттой нарийн танилцаж, түүний шаардлагуудыг чандлан биелүүлэх хүсэл, зориг, эрмэлзлэлтэй байх.

3.3 “Хүний их эмч” мэргэжлээр төгсөгчийн бэлтгэлд тавигдах үндсэн шаардлага.

3.3.1 “Хүний их эмч” мэргэжлээр төгсөгч нь дараах онолын мэдлэг эзэмшсэн байна. Үүнд:

3.3.1.1 Эрүүл хүний бие махбод, эрхтэн тогтолцоо, эд эсийн бүтэц, зохион байгуулалт, хэвийн үйл ажиллагаа;

3.3.1.2 Аливаа өвчин эмгэгийн үед хүний бие махбод, эрхтэн тогтолцоо, эс эдийн бүтэц, зохион байгуулалтад гарах өөрчлөлтүүд болон өвчин үүсэн даамжрах эмгэг жам;

3.3.1.3 Нян судлал болон хүний биед өвчин эмгэг үүсгэх бусад шалтгаан, нөхцөлдүүлэх хүчин зүйлс;

3.3.1.4 Хүний үр хөврөлийн үүсэл, өсөлт, хөгжлийн зүй тогтол, жам;

3.3.1.5 Хүний өвчин эмгэгийн үед хэрэглэх эмийн бэлдмэлүүдийн хими-физикийн шинж, эмийн бодис хүний бие махбод, эрхтэн тогтолцоонд үйлчлэх механизм;

3.3.1.6 Хүний нас, хүйснээс хамааран, зонхилон тохиолдох эрүүл мэндийн тулгамдсан асуудлууд, тэдгээрийн өвөрмөц, онцлог талууд;

3.3.1.7 Аливаа өвчин эмгэг үүсэхийн урьдал байдлууд ба эрсдэлт хүчин зүйлс;

3.3.1.8 Өвчний эхлэл буюу ялган оношлохуй, хамшинж, эмгэг байдал;

3.3.1.9 Хүний эрхтэн, тогтолцооны зонхилон тохиолдох өвчин эмгэгийн мөн чанар, шалтгаан, эмгэг жам, явц, үе шат, эмнэлзүйн хэлбэр, ангилал,

тавилан, төгсгөл, оношлогооны болон эмчилгээний арга зүйн талаарх орчин үеийн анагаах ухааны суурь мэдлэг;

3.3.1.10 Нийгмийн эрүүл мэндийн шинжлэх ухааны мөн чанар, судлах зүйлийн үндсэн агуулга, зорилго, зорилтууд, практикийн ач холбогдол;

3.3.1.11 Хүний эрүүл мэнд, эрүүл ахуйн талаарх суурь ойлголт, эрүүл байхын үндсэн нөхцлүүд, түүнд нөлөөлөх хүчин зүйлс;

3.3.1.12 Хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, өвчний тархвар зүй, биостатистикийн суурь ойлголт, үндсэн арга зүй, эмнэлгийн тусламжийг зохион байгуулах арга зүй, нийгмийн эрүүл мэндийн буюу урьдчилан сэргийлэлтийн үндсэн арга хэмжээнүүд, тэдгээрийг авч хэрэгжүүлэх арга зүй, иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох арга зүй;

3.3.1.13 Эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх аргууд, оношлогоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэлт, лабораторийн болон бусад шинжилгээний аргууд, шинжилгээний дүнд үнэлгээ дүгнэлт хийх.

3.3.2 "Хүний их эмч" мэргэжлээр төгсөгч нь дараах үр чадварыг эзэмшсэн байна.
Үүнд:

3.3.2.1 Үйлчлүүлэгчийг хүлээн авч асуух, харах, хүрэлцэх аргаар үзлэг хийж, олон улсын өвчний ангилал зүйн дагуу онош тогтоож, эмчилгээний зарчим боловсруулах, эмнэлзүйн шийдвэр гаргах;

3.3.2.2 Анхан шатны эмнэлгийн түвшингийн оношлогоо-эмчилгээний багаж, хэрэгслийг ашиглах;

3.3.2.3 Лаборатори, дүрс-оношлогоо, үйл-оношлогооны зэрэг шинжилгээний үзүүлэлтүүдийг уншиж, өвчний онош тавих болон өвчтөний биеийн байдал, эмчилгээний үр дүнг үнэлэхэд ашиглах;

3.3.2.4 Зонхилон тохиолдох өвчний оношийг тогтоох боломжгүй эсвэл эмчилгээний үр дүн гараагүй тохиолдолд өвчтөнийг дараагийн шатны лавлагаа тусламжид цаг алдалгүй илгээх "хаалга барих" арга барилыг эзэмшсэн байх;

3.3.2.5 Анхан шатны эмнэлэгт хийгдэх нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээнүүдийг гардан зохион байгуулах, өвчний тархвар зүйн чиглэлээр энгийн тандалт явуулж, үнэлгээ дүгнэлт өгөх;

3.3.2.6 Анхан шатны эмнэлгийн үйл ажиллагаанд биостатистикийн үндсэн аргуудыг ашиглан, задлан шинжилгээ хийх;

3.3.2.7 Эмнэлгийн анхан шатны маягт болон бусад холбогдох бичиг баримтыг стандартын дагуу хөтлөх;

3.3.2.8 Анхан шатны эмнэлгийн түвшинд хийгдэх оношлогоо-эмчилгээний дараах ажилбаруудыг гардан гүйцэтгэж чаддаг байх:

3.3.2.8.1 Антропометрийн хэмжилтүүд хийж, үнэлгээ өгөх;

- 3.3.2.8.2 Артерийн даралт хэмждэг тонометр болон гемометр, глюкометр, офтальмоскоп, риноскоп, отоскоп, мэдрэлийн алх, гинекологийн толь, мэс заслын зонд зэрэг энгийн багажууд болон шээсний сорилууд ашиглан, өвчтөнийг шинжилж, үнэлгээ өгч, онош тавьдаг байх;
- 3.3.2.8.3 Арьс, булчин, хураагуур судсанд тариа хийх;
- 3.3.2.8.4 Хэсэг газрыг мэдээгүйжүүлэх (новокаин, лидокаинаар хэсэг газарт хориг хийх зэрэг);
- 3.3.2.8.5 Арьсны цэвэр, бохир шархны анхны цэгцлэлт хийх;
- 3.3.2.8.6 Гадуур цус алдалтыг тогтоох;
- 3.3.2.8.7 Зөөлөн эд, үе, ясны гэмтлийн үед анхны тусламж үзүүлэх;
- 3.3.2.8.8 Зүрхний цахилгаан бичлэг хийж, үнэлгээ өгч, дүгнэлт гаргах;
- 3.3.2.8.9 Оношлогоо-эмчилгээний зорилгоор цээжний болон хэвлийн хөндийд хатгалт хийх;
- 3.3.2.8.10 Сэхээн амьдруулах анхны арга хэмжээ авах;
- 3.3.2.8.11 Хэвийн төрлөгийн үед эх барихуйн гардан үзүүлэх тусламж үзүүлэх ба хэвийн бус төрлөгийг тодорхойлох;
- 3.3.2.8.12 Бусад түгээмэл үйлдлүүд.

3.3.3 "Хүний их эмч мэргэжлээр төгсөгч нь дараах хандлага эзэмшсэн байна. Үүнд:

- 3.3.3.1 Үйлчлүүлэгч иргэд болон хамтран ажиллагсдаа нийгмийн гарал үүсэл, ёс заншил, арьс өнгө, нас, хүйсээр ялгаварлахгүй, нэр төрийг нь хүндэтгэж хандах;
- 3.3.3.2 Эмнэлгийн болон үйлчлүүлэгчийн нууцыг чанд хадгалж, өөрөө шийдвэр гаргах эрхийг хүндэтгэн хүлээн, зөвшөөрөх;
- 3.3.3.3 Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ, деонтологийн буюу үүрэг хариуцлагын дүрэм, журмыг ойлгож ухамсарласан байх.

Эрүүл мэндийн сайдын 2012 оны
04 сарын 02-ны өдрийн 102 тоот
тушаалын хоёрдугаар хавсралт

“Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн”
мэргэжлээр бакалавр зэрэгтэй төгсөгчид тавигдах шаардлага

1. Мэргэжлийн нэр: Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн
2. Мэргэжлийн индекс: D720100
3. Мэргэжлийн тодорхойлолт, тавигдах шаардлага

3.1 Мэргэжлийн тодорхойлолт:

Нийгмийн эрүүл мэндийн бакалаврын боловсрол эзэмшсэн мэргэжилтэн нь хүн амын эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тандах, судлах, хянах, эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгоход чиглэгдсэн арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах мэдлэг, чадвар, хандлага эзэмшсэн байна.

Төгсөгч нь онолын ба практикийн чиглэлээр судалгаа шинжилгээний ажил хийж болох ба цаашдаа төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалт, магистрантур, докторантурт суралцах эрхээр хангагдсан байна.

3.2 “Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн” мэргэжлээр төгсөгчийн бэлтгэлд тавигдах нийтлэг шаардлага. Үүнд:

3.2.1 Анагаах ухааны үндсэн салбар шинжлэх ухааны суурь онол, арга зүйг судалж, ойлгож мэдсэн, тэр хүрээнд хүн амын эрүүл мэндийг сахин хамгаалах үндсэн арга, зарчмуудыг үйл ажиллагаандаа хэрэглэж чаддаг байх;

3.2.2 Хүн амын эрүүл мэндтэй холбоотой аливаа асуудалд мэргэжлийн үүднээс бодитой хандаж, тулгамдаж буй асуудлыг шинжлэх ухаанчаар задлан шинжилж, үйл ажиллагаандаа шинжлэх ухааны үндэслэлтэй аргуудыг хэрэглэж чаддаг байх;

3.2.3 Байгаль, нийгэм, хүмүүсийн хоорондын харилцааг зохицуулдаг ёс зүй, хууль, эрх зүйн хэм хэмжээг мэддэг, сахидаг, энэ чиглэлээр тавигдах шаардлагуудыг ёсчлон биелүүлдэг, энэрэнгүй сэтгэлтэй байх;

3.2.4 Эрүүл аж төрөх ёсны талаар шинжлэх ухааны үндэслэл бүхий мэдлэгтэй байж, өөрийн бие бялдар, оюун санааг хөгжүүлэх чадвар, хандлага, дадлыг эзэмшсэн, бусад хүмүүст үлгэр дууриал үзүүлдэг байх;

3.2.5 Өөрийн үйл ажиллагаанд бодитойгоор дүн шинжилгээ хийх чадвартай, орчин үеийн мэдээллийн технологийг ашиглан, шинэ мэдлэг, мэдээлэл олж авах, бүтээлчээр ашиглах болон биеэ даан тасралтгүй суралцах чадвартай байх;

3.2.6 Мэргэжлийн ажил үүргээ биелүүлэхтэй холбогдуулан өмнөө тавигдах зорилго, зорилтуудыг оновчтой тодорхойлж, тэдгээрт хүрэх үйл ажиллагааг зохистой төлөвлөж чаддаг, биелүүлэхийн төлөө тууштай тэмцдэг байх;

3.2.7 Эрүүл мэндийн байгууллагын удирдлага, зохион байгуулалт, санхүүгийн менежментийн талаар зохих түвшний мэдлэгтэй байж, түүнийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлдэг байх;

3.2.8 Багаар ажиллах чадвартай, харилцааны соёл бүхий ур чадвар эзэмшсэн, өөрийгөө хүнд ойлгуулах, бусдад зөвлөгөө өгөх ур чадвартай, үйлчлүүлэгчийн санал хүсэлтийг хүндэтгэн туслах, хариуцлага хүлээх чадвартай байх;

3.2.9 Англи хэлийг өдөр тутмын болон мэргэжлийн үйл ажиллагаандаа хэрэглэх;

3.2.10 Мэдээлэл зүй, компьютерийн хэрэглээний программуудыг хэрэглэх;

3.2.11 Ажиллаж буй байгууллагын дотоод дүрэм журам, цагийн хуваарийг чанд баримтлах;

3.2.12 Өөрийн ажлын байрны тодорхойлолттой нарийн танилцаж, түүний шаардлагуудыг чандлан биелүүлэх хүсэл, зориг, эрмэлзлэлтэй байх.

3.3 “Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн” мэргэжлээр төгсөгчийн бэлтгэлд тавигдах үндсэн шаардлага. Үүнд:

3.3.1 Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтний эзэмшсэн байх онолын мэдлэг:

3.3.1.1 Нийгмийн эрүүл мэндийн суурь зарчмууд, хүн амын эрүүл мэндийн тухай үндсэн ойлголт: эрүүл мэндийн шинжлэх ухааны түүх, эрүүл мэнд, түүнийг тодорхойлогч хүчин зүйлс, зан үйл, ёс заншил, соёл, орчны эрүүл мэндэд нөлөөлөх нөлөө, эрүүл мэндтэй холбоотой хууль эрх зүйн орчин, тэгш байдал ба эрүүл мэнд, ёс зүй, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, түүний эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд эзлэх байр суурь;

3.3.1.2 Эрүүл мэндийн удирдлагын үндэс: эрүүл мэндийн тусламж үйлчилгээний ерөнхий ойлголт, байгууллагын бүтэц зохион байгуулалт, стратегийн төлөвлөлт ба удирдлага, засаглалын тухай ойлголт, хүний нөөцийн удирдлага, удирдлагын арга хэрэгслүүд, төсвийн удирдлагын үндэс, гүйцэтгэл, бүтээмжийн удирдлага, түүний хяналт-шинжилгээ, үнэлгээ, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын удирдлага;

3.3.1.3 Эрүүл мэндийн тогтолцооны талаарх ерөнхий ойлголт: улс орнуудын эрүүл мэндийн тогтолцооны хэв шинжийг харьцуулах, эрүүл мэндийн бодлого боловсруулах, бодлогын дүн шинжилгээ хийх, Засгийн газар ба эрүүл мэндийн бодлого, хүн амын эрүүл мэндийг сайжруулах хөтөлбөрүүд, түүний хэрэгжилтийг үнэлэхэд хүн амын эрүүл мэндийн үзүүлэлтүүдийг ашиглах, хүн амын эрүүл мэндийн үзүүлэлтүүдийн тухай ойлголт, эрүүл мэндийн судалгааны аргууд, хүн амын эмзэг бүлэг (ядуу иргэд, хүүхэд, эмэгтэйчүүд, өндөр настан, хэл, ёс заншил, шашин шүтлэгийн хувьд хүн амын цөөнхийн бүлэг зэрэг)-ийн эрүүл мэндийн талаарх бодлого;

- 3.3.1.4 Эрүүл мэндийн эдийн засаг, санхүүжилтийн үндэс: нягтлан бодох бүртгэлийн талаарх суурь ойлголт, санхүүгийн гүйлгээг бүртгэж авах аргууд, төсөвлөлтийн аргууд, эдийн засгийн үндсэн ойлголт, зах зээлийн тогтолцооны тухай ерөнхий ойлголт, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрэлт ба нийлүүлэлт; эрүүл мэндийн даатгалын тогтолцооны тухай ерөнхий мэдээлэл, даатгалын тогтолцооны хэв шинжүүд.
- 3.3.1.5 Тархвар зүйн шинжлэх ухааны үндэс: түүхэн хөгжил, үндсэн зарчмууд, хүн амын эрүүл мэндийн түвшин, тархвар зүйн судалгааны арга хэрэгслүүд, өгөгдлийн менежмент, тархвар зүйн судалгааны үр дүнг ойлгох, судалгааны ажлын үр дүнг танилцуулах хүснэгт, график дүрслэл ашиглах, судалгааны хүчин төгөлдөр байдлыг үнэлэх, судалгааны ажилд шүүмж өгөх, судалгааны ажлын үр дүнг хэвлүүлэхэд тавигдах нийтлэг шаардлага, биоанагаахын ёс зүйн үндсэн зарчмууд;
- 3.3.1.6 Хэрэглээний тархвар зүйн талаархи үндсэн ойлголт: халдварт болон халдварт бус өвчний тархвар зүй, орчны эрүүл мэнд ба тархвар зүй, эмнэл зүйн тархвар зүй, хүн ам зүй ба тархвар зүй, ДОХ/ХДХВ/БЗХӨ-ний тархвар зүй, талбарын тархвар зүй;
- 3.3.1.7 Биостатистикийн суурь мэдлэг: магадлалын онолын үндэс, тархалтын тухай ойлголт, хүн амын үзүүлэлтүүд, тэдгээрийг түүвэрлэлтээр тооцоолон хэмжих, таамаглал шалгах статистик боловсруулалтын аргууд, шугаман хамаарал болон регрессийн аргууд, параметрикийн бус аргуудын талаарх мэдлэг, статистик боловсруулалтын үр дүнг ойлгох тайлбарлах талаарх мэдлэг;
- 3.3.1.8 Зан үйл судлалын үндсэн ойлголтууд: хүн амын эрүүл мэнд болон эрүүл мэндтэй холбоотой зан үйлд нөлөөлөх нийгэм, сэтгэл зүйн хүчин зүйлүүдийн талаархи ерөнхий ойлголт, эрүүл мэндийг дэмжих онолын үндэс буюу зан үйлийн үндсэн онолууд, эрүүл мэндийг дэмжих хөтөлбөрийг боловсруулах, төлөвлөх, хэрэгжүүлэх үндсэн зарчмууд, эрүүл мэндийг дэмжих арга хэмжээнд ашиглах арга хэрэгслүүд, эрсдэлтэй зан үйлийг өөрчлөх, эрүүл зан үйлийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн хөтөлбөр, арга хэмжээнд явцын, үр дүнгийн, үр нөлөөний үнэлгээ хийх судалгааны аргууд, чанарын судалгааны онол ба арга зүй, чанарын судалгааны үр дүнд боловсруулалт хийх;
- 3.3.1.9 Нөхөн үржихүйн эрүүл мэндийн тухай ерөнхий ойлголт: эх, хүүхдийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлууд, түүнд нөлөөлөх хүчин зүйлс, нөхөн үржихүйн эрүүл мэндийн бодлогын үндэс, нөхөн үржихүйн эрүүл мэндийн хөтөлбөр, гэр бүл төлөвлөлт, эх хүүхдийн эндэгдлийг бууруулах стратеги;
- 3.3.1.10 Хүүхэд, өсвөр үеийн эрүүл мэндийн тухай ерөнхий ойлголт: хүний амьдралын үе шатууд ба эрүүл мэнд, пренаталь шат нярайн өсөлт, хөгжилт, хүүхдийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлууд, хүүхдийн эрүүл мэнд ба хоол тэжээл, хүүхдийн өвчлөлийн тархвар зүй, өсвөр үеийнхний эрүүл мэндийн нийгэм сэтгэл зүйн асуудлууд, өсвөр үеийнхний эрүүл мэндийн асуудлууд (бэлгийн эрүүл мэнд, өсвөр насны жирэмслэлт, хорт зуршил, сэтгэцийн эрүүл мэнд зэрэг);

- 3.3.1.11 Эрүүл мэнд, өвчлөл, эрсдэлт хүчин зүйлд хоол хүнсний үүрэг, хүний амьдралын үе шат ба хоол хүнсний хэрэглээ, хоол хүнсний хэрэглээг судлах арга зүй, хүний биеийн хоол тэжээлийн түвшинг судлах арга зүй, хоол хүнсний хэрэглээтэй холбоотой үүсэх эмгэгүүд, эрсдэлт нөхцөл байдал тэдгээрийн тархвар зүй, хүнсний эрүүл ахуйн шаардлага ба түүнийг хянах, хүнсний нэмэлт бүтээгдэхүүн ба эрүүл мэнд, хоолны жорын тухай үндсэн ойлголт, хүнсний технологи;
- 3.3.1.12 Орчны эрүүл мэнд, хөдөлмөрийн эрүүл ахуйн суурь мэдлэг: эрүүл мэндэд нөлөөлөх орчны (хими, физик, биологийн) хүчин зүйлийн нөлөө, экологийн тэнцвэрт байдлын 5 глобал хүчин зүйл: газрын ашиглалт, эрчим хүчний хэрэглээ, хоол хүнсний хэрэглээ, усны хэрэглээ, хүн амын өсөлт, орчны бохирдолтыг агаар, хөрс, ус, ажлын байр, ахуйн нөхцөлд хэмжих аргууд, хөдөлмөрийн эрүүл ахуйн үндсэн зарчмууд, хөдөлмөрийн аюулгүй байдал, хор судлалын үндэс, орчны эрсдэлт хүчин зүйлийн нөлөөг арилгах, бууруулахад чиглэсэн арга хэмжээ, мэргэжлээс шалтгаалах өвчний хяналт;
- 3.3.1.13 Сэтгэцийн эрүүл мэндийн үндсэн ойлголт: хүний сэтгэцийн эрүүл мэндийн хөгжил, сэтгэцийн эрүүл мэнд ба нийгэм, соёлын асуудлууд, сэтгэцийн эрүүл мэнд ба ёс зүй, сэтгэцийн эрүүл мэндийн үнэлэх, сэтгэцийн эмгэгийг оношлох аргууд, сэтгэцийн эрүүл мэндийн зөвлөгөө өгөх арга зүй, сэтгэцийн эрүүл мэнд ба хамт олны оролцоо, мансуурал судлалын үндэс, архи, мансууруулах болон сэтгэц нөлөөт бодисын хэрэглээ;
- 3.3.1.14 Халдварт бус өвчний урьдчилан сэргийлэлт, хяналт: тархвар зүйн шилжилтийн тухай ойлголт, хүн амын өвчлөл, нас баралтад халдварт бус өвчний эзлэх байр суурь, халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх стратеги, илрүүлгийн арга, халдварт бус өвчний хяналтын зарчим, зонхилон тохиолдох халдварт бус өвчний тархалтын түвшин, халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах хөтөлбөрийн үндсэн зарчим;
- 3.3.1.15 Эрүүл мэндийн удирдлагын мэдээллийн тогтолцоо, цахим эрүүл мэнд: нотолгоонд тулгуурласан шийдвэр гаргалт, мэдээллийн тогтолцоонд тавигдах шаардлагууд, хүн амын эрүүл мэндийн статистик мэдээллийг бүртгэх, нэгтгэх, боловсруулах, эргэн мэдээлэхэд баримтлах үндсэн зарчмууд, мэдээллийн технологийн дэвшил эрүүл мэндийн салбарт, эмнэлгийн мэдээллийн иж бүрэн тогтолцоо ба цаасгүй эмнэлэг, алсын зайн анагаах ухаан.

3.3.2 “Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн” мэргэжлээр төгсөгч нь дараах үр чадврыг эзэмшсэн байна:

- 3.3.2.1 Тусламж, үйлчилгээний удирдлага, бодлогын орчны дүн шинжилгээ хийх тэргүүлэх ач холбогдлыг тогтоох, төлөвлөх, хэрэгжилтийн зохицуулалт, хэрэгцээний дүн шинжилгээ, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;
- 3.3.2.2 Тархвар зүйн судалгааг төлөвлөх, гүйцэтгэх, тархвар зүйн судалгааны оновчтой аргыг сонгох, судалгааны тархвар зүйн судалгааг гүйцэтгэх,


тархвар зүйн судалгааны тайланг уншиж ойлгох, судалгааны хүчин төгөлдөр байдлыг үнэлэх, шүүмж өгөх;

- 3.3.2.3 Биостатистик, статистикийн дүн шинжилгээ хийсэн үр дүнг ойлгох, өгөгдөлд боловсруулалт хийх, зарим статистикийн дүн шинжилгээ хийх, статистик боловсруулалтын программ хангамж ашиглах;
- 3.3.2.4 Сургалт сурталчилгааны материал боловсруулах, үнэлэх, чанарын судалгааны аргуудыг эзэмшсэн байх, зан үйлийг өөрчлөх аргуудыг хэрэгжүүлэх чадвар эзэмшсэн байх;
- 3.3.2.5 Орчны эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ хийх, орчны халгаат хүчин зүйлийг хэмжих, хянах аргуудыг эзэмшсэн байх;
- 3.3.2.6 Бүртгэлийн маягыг хөтлөх, тайлан боловсруулах, өвчний олон улсын ангиллын дагуу кодлох, мэдээллийг танилцуулах, нотолгоонд суурилсан шийдвэр гаргах чадвар эзэмшсэн байх.

3.3.3 “Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн” мэргэжлээр төгсөгч нь дараах хандлага эзэмшсэн байна. Үүнд:

- 3.3.3.1 Үйлчлүүлэгч иргэд болон хамтран ажиллагсдаа нийгмийн гарал үүсэл, ёс заншил, арьс өнгө, нас, хүйсээр ялгаварлахгүй, нэр төрийг нь хүндэтгэж хандах;
- 3.3.3.2 Эмнэлгийн болон үйлчлүүлэгчийн нууцыг чанд хадгалж, өөрөө шийдвэр гаргах эрхийг хүндэтгэн хүлээн, зөвшөөрөх;
- 3.3.3.3 Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ, деонтологийн буюу үүрэг хариуцлагын дүрэм, журмыг ойлгож ухамсарласан байх.

Эрүүл мэндийн сайдын 2012 оны
04 сарын 02-ны өдрийн 02/1 тоот
тушаалын гуравдугаар хавсралт



“Нүүр амны их эмч” мэргэжлээр бакалавр
зэрэгтэй төгсөгчид тавигдах шаардлага

- 1. Мэргэжлийн нэр: Нүүр амны их эмч
- 2. Мэргэжлийн индекс: D722700
- 3. Мэргэжлийн тодорхойлолт, тавигдах шаардлага

3.1 “Нүүр амны их эмч” мэргэжлийн тодорхойлолт:

Анагаах ухааны бакалаврын боловсрол эзэмшсэн нүүр амны их эмч нь нүүр амны түгээмэл тохиолдох өвчин эмгэгүүд, согог, гажгуудын шалтгаан, эмгэг жам, эмнэл зүй, оношлогоо, эмчилгээ ба сэргийлэх үндсэн зарчмыг судалж, нүүр амны мэргэжлийн ерөнхий тусламж үйлчилгээг хүргэх, оношлогоо ба эмчилгээ хийх, нүүр амны алдагдсан үйл ажиллагааг нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэх, анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлэх мэдлэг, чадвар, хандлага эзэмшсэн мэргэжилтэн байна.

Төгсөгч онолын ба практикийн чиглэлээр судалгаа шинжилгээний ажил хийж болох ба цаашдаа төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалт, магистрантур, докторантурт суралцах эрхээр хангагдсан байна.

3.2 “Нүүр амны их эмч” мэргэжлээр төгсөгчийн бэлтгэлд тавигдах нийтлэг шаардлага. Үүнд:

3.2.1 Анагаах ухааны үндсэн салбар шинжлэх ухааны суурь онол, арга зүйг судалж, ойлгож мэдсэн, тэр хүрээнд хүн амын эрүүл мэндийг сахин хамгаалах үндсэн арга, зарчмуудыг үйл ажиллагаандаа хэрэглэж чаддаг байх;

3.2.2 Хүн амын эрүүл мэндтэй холбоотой аливаа асуудалд мэргэжлийн үүднээс бодитой хандаж, тулгамдаж буй асуудлыг шинжлэх ухаанчаар задлан шинжилж, үйл ажиллагаандаа шинжлэх ухааны үндэслэлтэй аргуудыг хэрэглэж чаддаг байх;

3.2.3 Байгаль, нийгэм, хүмүүсийн хоорондын харилцааг зохицуулдаг ёс зүй, хууль, эрх зүйн хэм хэмжээг мэддэг, сахидаг, энэ чиглэлээр тавигдах шаардлагуудыг ёсчлон биелүүлдэг, энэрэнгүй сэтгэлтэй байх;

3.2.4 Эрүүл аж төрөх ёсны талаар шинжлэх ухааны үндэслэл бүхий мэдлэгтэй байж, өөрийн бие бялдар, оюун санааг хөгжүүлэх чадвар, хандлага, дадлыг эзэмшсэн, түүгээрээ бусад хүмүүст үлгэр дууриал үзүүлдэг байх;

3.2.5 Өөрийн үйл ажиллагаанд бодитойгоор дүн шинжилгээ хийх чадвартай, орчин үеийн мэдээллийн технологийг ашиглан, шинэ мэдлэг, мэдээлэл олж авах, бүтээлчээр ашиглах болон биеэ даан тасралтгүй суралцах чадвартай байх;

3.2.6 Мэргэжлийн ажил үүргээ биелүүлэхтэй холбогдуулан өмнөө тавигдах зорилго, зорилтуудыг оновчтой тодорхойлж, тэдгээрт хүрэх үйл ажиллагаагаа зохистой төлөвлөж чаддаг, биелүүлэхийн төлөө тууштай тэмцдэг байх;

3.2.7 Эрүүл мэндийн байгууллагын удирдлага, зохион байгуулалт, санхүүгийн менежментийн талаар зохих түвшний мэдлэгтэй байж, түүнийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлдэг байх;

3.2.8 Багаар ажиллах чадвартай, харилцааны соёл бүхий ур чадвар эзэмшсэн, өөрийгөө хүнд ойлгуулах, бусдад зөвлөгөө өгөх ур чадвартай, үйлчлүүлэгчийн санал хүсэлтийг хүндэтгэн туслах, хариуцлага хүлээх чадвартай байх;

3.2.9 Англи хэлийг өдөр тутмын болон мэргэжлийн үйл ажиллагаандаа хэрэглэх;

3.2.10 Мэдээлэл зүй, компьютерийн хэрэглээний программуудыг хэрэглэх;

3.2.11 Ажиллаж буй байгууллагын дотоод дүрэм, журам, цагийн хуваарийг чанд баримтлах;

3.2.12 Өөрийн ажлын байрны тодорхойлолттой нарийн танилцаж, түүний шаардлагуудыг чандлан биелүүлэх хүсэл, зориг, эрмэлзлэлтэй байх.

3.3 “Нүүр амны их эмч” мэргэжлээр төгсөгчийн бэлтгэлд тавигдах үндсэн шаардлага

3.3.1 Нүүр амны их эмч мэргэжлээр төгсөгч нь дараах онолын мэдлэг эзэмшсэн байна. Үүнд:

3.3.1.1 Нүүр ам судлалын үзлэгийн кабинет (эмчилгээ, мэс засал, согог засал, гажиг засал, хүүхдийн нүүр ам, урьдчилан сэргийлэлт)-ын зохион байгуулалт, өргөн хэрэглэгдэх тоног төхөөрөмж, багаж, хэрэгслүүд, тэдгээрийг хэрэглэх заавар, ажиллах зарчим, ариутгал халдваргүйтгэл, устгал;

3.3.1.2 Нүүр амны өвчин, эмгэгүүдийн оношлогоо, эмчилгээ хийхэд өргөн хэрэглэгдэх материал, эм бэлдмэлийн шинж чанар, орцын норм, найрлага, хэрэглэх заалт, аргачлал, хадгалалт, устгал;

3.3.1.3 “Нүүр амны их эмч”-ийн хөдөлмөр зохион байгуулалт, ажлын хувцас, хамгаалах хэрэгслүүдийн хэрэглээ;

3.3.1.4 Үйлчлүүлэгчээс асуумж авах, бодит үзлэг, туслах шинжилгээний аргуудаар шинжлэх, оношлох, эмчилгээний төлөвлөгөө боловсруулах ерөнхий зарчим;

3.3.1.5 Цоорлын бус гаралтай шүдний хатуу эдийн эмгэгүүдийн шалтгаан, эмгэг жам, эмнэл зүй, оношлогоо, эмчилгээний арга, урьдчилан сэргийлэлт;

3.3.1.6 Шүд цоорох өвчин үүсэх шалтгаан, эмгэг жам, эмнэл зүйн хэлбэрүүд, оношлогоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэлт, өвчлөлийг судлах аргууд;

- 3.3.1.7 Шүдний зөөлц, холбоосын үрэвсэл үүсэх шалтгаан, эмгэг жам, эмнэл зүй, оношлогоо, эмчилгээний арга, сувагт хэрэглэгдэх багаж, ариутгалын уусмал, сувгийн эмчилгээний материал;
- 3.3.1.8 Буйлны үрэвслийн үүсэх шалтгаан, эмгэг жам, эмнэл зүй, оношлогоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэлт;
- 3.3.1.9 Шүдний тулгуур эдийн үрэвсэлт өвчин ба тулгуур эдийн хатингаршлын үүсэх шалтгаан, бие махбодын өвчний нөлөө, эмгэг жам, оношлогоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэлт;
- 3.3.1.10 Амны салстын түгээмэл тохиолдох эмгэг (гэмтэл, бусад эрхтэний эмгэгийн үед амны салстад гарах өөрчлөлт, мөөгөнцөр, хавдрын урьдал эмгэг, хэл ба уруулын үрэвсэл)-ийн шалтгаан, эмгэг жам, эмнэл зүй, оношлогоо, ялгах онош, эмчилгээ, урьдчилан сэргийлэх ерөнхий зарчим;
- 3.3.1.11 Эрүү, нүүр орчмын гэмтлийн шалтгаан, эмгэг жам, ангилал, эмнэл зүй, оношлогоо, эмчилгээний зарчим;
- 3.3.1.12 Нүүрний мэдрэлийн тогтолцооны эмгэг (тархины 5 ба 7 дугаар хос мэдрэл)-ийн шалтгаан, эмгэг жам, ангилал, эмнэл зүй, оношлогоо, эмчилгээний зарчим;
- 3.3.1.13 Эрүү, нүүр орчмын зөөлөн эд, ясны төрөлхийн ба олдмол гажгийн шалтгаан, эмгэг жам, ангилал, эмнэл зүй, оношлогоо, тэдгээрийг нөхөн сэргээх зарчим;
- 3.3.1.14 Сүүн ба байнгын шүд шүдлэх дараалал, шүдлэх хугацаа, сурвалж хэлбэржих, шимэгдэх хугацаа;
- 3.3.1.15 Хүүхдийн төрөлхийн ба олдмол согог, гажгийн үүсэх шалтгаан, эмгэг жам, ангилал, эмнэл зүй, оношлогоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэх зарчим;
- 3.3.1.16 Нүүр амны мэс засалд хэрэглэгдэх ерөнхий ба хэсгийн мэдээ алдуулалт, хэрэглэх онцлог, шүд авах арга барилууд;
- 3.3.1.17 Эрүү, нүүр орчмын хавдрын урьдал өвчнүүд, хоргүй ба хортой хавдрын шалтгаан, эмнэл зүй, оношлогоо, эмчилгээний зарчим;
- 3.3.1.18 Шүдэлбэр зүйн төрөл, шүдний цөгц, эгнээний согог, бүрэн шүдгүйдлийн шалтгаан, эмгэг жам, ангилал, эмнэл зүй, оношлогоо, эмчилгээний зарчим;
- 3.3.1.19 Шүдний эмгэг элэгдлийн шалтгаан, эмгэг жам, ангилал, эмнэл зүй, оношлогоо, эмчилгээний зарчим, эрүүл, эмгэг зуултын төлөвийн ялган оношлогоо;
- 3.3.1.20 Нүүр амны өвчний урьдчилан сэргийлэлт, амны хөндийн эрүүл мэндийн боловсрол олгох сургалт явуулах, шүд цоорох өвчнөөс урьдчилан сэргийлэх, амны хөндийн эрүүл ахуй тодорхойлох,

цэцэрлэг, сургуулийн насны хүүхдэд амны хөндийн эрүүл ахуйн мэдлэг, дадал олгох аргууд;

3.3.1.21 Эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх аргууд.

3.3.2 Нүүр амны их эмч мэргэжлээр төгсөгч нь дараах ур чадварыг эзэмшсэн байна. Үүнд:

3.3.2.1 Үйлчлүүлэгчээс асуумж авч, эрүү нүүр орчим, амны хөндийн үзлэг хийх;

3.3.2.2 Нүүр амны их эмчийн ажлын хувцас, хамгаалах хэрэгслүүдийг хэрэглэх;

3.3.2.3 Нүүр ам судлалын үзлэгийн кабинет (эмчилгээ, мэс засал, согог засал, гажиг засал, хүүхдийн нүүр ам, урьдчилан сэргийлэлт)-д өргөн ашиглагддаг тоног төхөөрөмж, багаж хэрэгслүүдийг хэрэглэх, тоног төхөөрөмж, багаж, хэрэгслүүдийн ариутгал, халдваргүйтлийн дэглэмийг баримтлан ажиллах;

3.3.2.4 Эмнэлгийн анхан шатны маягт болон бусад холбогдох бичиг баримтыг стандартын дагуу хөтлөх;

3.3.2.5 Дараах оношлогоо-эмчилгээний ажилбаруудыг гүйцэтгэж чаддаг байх:

3.3.2.5.1 Нүүр амны үрэвсэлт өвчнүүдийн үед шүдний ба дэлгэмэл рентген зургийг уншиж өвчний явцыг тодорхойлох;

3.3.2.5.2 Буйлны үрэвслийн хэлбэр, эрүү, нүүр орчмын үрэвслүүд, гэмтлийг оношлох, эмчлэх;

3.3.2.5.3 Шүдний цоорлын бүх хэлбэрийг оношлох, эмчлэх, урьдчилан сэргийлэх;

3.3.2.5.4 Гипоплази, флюороз, шаант хэлбэрийн согогийг оношлох, эмчлэх;

3.3.2.5.5 Зөөлц, холбоосын үрэвслийн түгээмэл хэлбэрийг оношлон, эмийн аргаар эмчлэх;

3.3.2.5.6 Нэг ба хоёр шулуун сурвалжтай шүдний сувгийг эмийн аргаар эмчлэх;

3.3.2.5.7 Шүдний өнгөр цэвэрлэх, чулуу авах;

3.3.2.5.8 Хүүхдийн шүдний гажгийг оношлох;

3.3.2.5.9 Шүд угаах аргыг эзэмшин, фторт гель, лак, силантуудыг хэрэглэх;

3.3.2.5.10 Эрүү, нүүр орчмын хэсгийн мэдээгүйжүүлэлт (шингээх, нэвчүүлэх, дамжуулах)-ийг хийх, ердийн байрлалтай нэг ба олон сурвалжтай шүд авах;

- 3.3.2.5.11 Өнгөц байрлалтай буглаа, ясны хальсны үрэвсэл, хатиг нээх, боолт хийх;
- 3.3.2.5.12 Эрүү, хоншоорын хугаралд түр боолт, бэхэлгээ хийх
- 3.3.2.5.13 Хэв авах, загвар цутгах, голлосон хоршихуйг тодорхойлох, энгийн хийцтэй шүдэлбэрийн хийцийг зохиомжлох, өвчтөнд шүдэлбэр суулгах, зөвлөгөө өгөх;
- 3.3.2.5.14 Амны хөндийн эрүүл мэндийн боловсрол олгох сургалт явуулах;
- 3.3.2.5.15 Сэхээн амьдруулах анхны арга хэмжээ авах.

3.3.3 Нүүр амны их эмч мэргэжлээр төгсөгч нь дараах хандлага эзэмшсэн байна. Үүнд:

- 3.3.3.1 Үйлчлүүлэгч иргэд болон хамтран ажиллагсдаа нийгмийн гарал үүсэл, ёс заншил, арьс өнгө, нас, хүйсээр ялгаварлахгүй, нэр төрийг нь хүндэтгэж хандах;
- 3.3.3.2 Эмнэлгийн болон үйлчлүүлэгчийн нууцыг чанд хадгалж, өөрөө шийдвэр гаргах эрхийг хүндэтгэн хүлээн, зөвшөөрөх;
- 3.3.3.3 Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ, деонтологийн буюу үүрэг хариуцлагын дүрэм, журмыг ойлгож ухамсарласан байх.

Эрүүл мэндийн сайдын 2012 оны
04 сарын 02-ны өдрийн 102 тоот
тушаалын дөрөвдүгээр хавсралт

“Уламжлалт анагаахын их эмч” мэргэжлээр
бакалавр зэрэгтэй төгсөгчид тавигдах шаардлага

1. Мэргэжлийн нэр: Уламжлалт анагаахын их эмч
2. Мэргэжлийн индекс: D 722000
3. Мэргэжлийн тодорхойлолт, тавигдах шаардлага

3.1 “Уламжлалт анагаахын их эмч” мэргэжлийн тодорхойлолт:

Анагаах ухааны бакалаврын боловсрол эзэмшсэн уламжлалт анагаахын их эмч нь хүн амын эрүүл мэнд, эмнэлгийн тусламж үйлчилгээний бодлоготой нягт уялдуулан өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх талаар уламжлалт анагаахын онолын мэдлэг, ур чадварыг эзэмшсэн, эм барих арга барил болон гардан хийх үйлдэлд дадлагажсан мэргэжилтэн байна.

Төгсөгч нь онолын ба практикийн чиглэлээр судалгаа шинжилгээний ажил хийж болох ба төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалт, магистрантур, докторантурт суралцах эрхээр хангагдсан байна.

3.2 “Уламжлалт анагаахын их эмч” мэргэжлээр төгсөгчийн бэлтгэлд тавигдах нийтлэг шаардлага. Үүнд:

3.2.1 Анагаах ухааны үндсэн салбар шинжлэх ухаан, уламжлалт анагаах ухааны суурь онол, арга зүйг судалж, ойлгож мэдсэн, тэр хүрээнд хүн амын эрүүл мэндийг сахин хамгаалах үндсэн арга, зарчмуудыг үйл ажиллагаандаа хэрэглэж чаддаг байх;

3.2.2 Хүн амын эрүүл мэндтэй холбоотой аливаа асуудалд мэргэжлийн үүднээс бодитой хандаж, тулгамдаж буй асуудлыг шинжлэх ухаанчаар задлан шинжилж, үйл ажиллагаандаа шинжлэх ухааны үндэслэлтэй аргуудыг хэрэглэж чаддаг байх;

3.2.3 Байгаль, нийгэм, хүмүүсийн хоорондын харилцааг зохицуулдаг ёс зүй, хууль, эрх зүйн хэм хэмжээг мэддэг, сахидаг, энэ чиглэлээр тавигдах шаардлагуудыг ёсчлон биелүүлдэг, энэрэнгүй сэтгэлтэй байх;

3.2.4 Эрүүл аж төрөх ёсны талаар шинжлэх ухааны үндэслэл бүхий мэдлэгтэй байж, өөрийн бие бялдар, оюун санааг хөгжүүлэх чадвар, хандлага, дадлыг эзэмшсэн, түүгээрээ бусад хүмүүст үлгэр дууриал үзүүлдэг байх;

3.2.5 Өөрийн үйл ажиллагаанд бодитойгоор дүн шинжилгээ хийх чадвартай, орчин үеийн мэдээллийн технологийг ашиглан, шинэ мэдлэг, мэдээлэл олж авах, бүтээлчээр ашиглах болон биеэ даан тасралтгүй суралцах чадвартай байх;

3.2.6 Мэргэжлийн ажил үүргээ биелүүлэхтэй холбогдуулан өмнөө тавигдах зорилго, зорилтуудыг оновчтой тодорхойлж, тэдгээрт хүрэх үйл ажиллагаагаа зохистой төлөвлөж чаддаг, биелүүлэхийн төлөө тууштай тэмцдэг байх;

3.2.7 Эрүүл мэндийн байгууллагын удирдлага, зохион байгуулалт, санхүүгийн менежментийн талаар зохих түвшний мэдлэгтэй байж, түүнийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлдэг байх;

3.2.8 Багаар ажиллах чадвартай, харилцааны соёл бүхий ур чадвар эзэмшсэн, өөрийгөө хүнд ойлгуулах, бусдад зөвлөгөө өгөх ур чадвартай, үйлчлүүлэгчийн санал хүсэлтийг хүндэтгэн туслах, хариуцлага хүлээх чадвартай байх;

3.2.9 Англи хэлийг өдөр тутмын болон мэргэжлийн үйл ажиллагаандаа хэрэглэх;

3.2.10 Мэдээлэл зүй, компьютерийн хэрэглээний программуудыг хэрэглэх;

3.2.11 Ажиллаж буй байгууллагын дотоод дүрэм журам, цагийн хуваарийг чанд баримтлах;

3.2.12 Өөрийн ажлын байрны тодорхойлолттой нарийн танилцаж, түүний шаардлагуудыг чандлан биелүүлэх хүсэл, зориг, эрмэлзлэлтэй байх.

3.2 Уламжлалт анагаахын их эмч мэргэжлээр төгсөгчийн бэлтгэлд тавигдах үндсэн шаардлага.

3.3.1 “Уламжлалт анагаах ухааны их эмч” мэргэжлээр төгсөгч нь дараах онолын мэдлэг эзэмшсэн байна. Үүнд:

3.3.1.1 Ертөнцийг үзэх уламжлалт анагаахын болон шинжлэх ухааны философийн үзэл онол, түүх, нийгэм, эдийн засаг, хууль эрх зүй, зурхай, байгалийн шинжлэлийн тулгуур ойлголт;

3.3.1.2 Хүний биеийн эрүүл ба эмгэг бүтэц, үйл ажиллагаа, тунгалаг цөвийн боловсролт, түүний зүй тогтол, эрхтэн тогтолцооны харилцаа холбоо, өвчний шалтгаан, нөхцөл, эмгэг жам, эмнэл зүйн илрэл;

3.3.1.3 Идээ ундны зохистой хэрэглээ, хоол эмчилгээ, ахуй үес, өдөр хоног, улирлын хэмнэлтэй уялдуулсан бие, хэл, сэтгэлийн зохистой явдал мөр, хүчжүүлэг, өвчнөөс урьдчилан сэргийлэх арга;

3.3.1.4 Байгалийн гаралтай эмийн түүхий эдийн нэр нэршил, амт, чадал, эрдэм, түүнийг номхотгох, бэлтгэх, жорлох арга, амарлиулах болон арилгах үйлдэлтэй эмийг хэрэглэх заалт, тун хэмжээ;

3.3.1.5 Өвчнийг судас, шээс болон бусад аргаар оношлох, эмчилгээний зарчим;

3.3.1.6 Гурван гэм хурмал өвчин, дотор өвчин, халуун өвчин, таван эрхтний өвчин, цул сав эрхтний өвчин, нууцын өвчин, хэсэг бусад өвчин, хамт төрсөн шарх, нялхсын өвчин, эмэгтэйн өвчин, адын өвчин, бэртэл гэмтэл, хорын өвчин, хөгшидийн өвчний шалтгаан, нөхцөл, эмгэг жам, шинж тэмдэг, оношлогоо, эмчилгээ;

- 3.3.1.7 Хануур, төөнүүр, жин, дэвтээлэг, хатгуур, зүү, бариа, засал, бясалгал, тарнийн эмчилгээний аргууд, хүндрэлээс урьдчилан сэргийлэх;
- 3.3.1.8 Өрнийн анагаахын онолоор зонхилон тохиолдох өвчин эмгэг, дотор өвчин, эх барих эмэгтэйчүүд, халдварт өвчин, хавдар, арьс, өнгөний өвчин, эх барих эмэгтэйчүүдийн өвчин, мэс заслын өвчнүүдийн шалтгаан, эмнэл зүй, оношлогоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэлт;
- 3.3.1.9 Яаралтай тусламж үзүүлэх аргууд, оношлогоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэлт, лаборатори шинжилгээний аргууд, шинжилгээнд дүгнэлт хийх.
- 3.3.2 “Уламжлалт анагаах ухааны их эмч” мэргэжлээр төгсөгч нь дараах үр чадвар эзэмшсэн байна. Үүнд:
- 3.3.2.1 Үйлчлүүлэгчийг хүлээн авч асуух, харах, хүрэлцэх аргаар үзлэг, оношлогоо хийн уламжлалт анагаахын өвчний ангилал зүйн дагуу онош тогтоож, эмчилгээний зарчим боловсруулах, эмнэлзүйн шийдвэр гаргах;
- 3.3.2.2 Өвчтөнд илэрч буй өөрчлөлтийг лаборатори болон багажийн шинжилгээний хариуг уншиж, үнэлэлт, дүгнэлт хийх;
- 3.3.2.3 Уламжлалт дан болон олон найрлагат амарлиулах болон арилгах үйлдэлтэй эм, зөөлөн, ширүүн засал, бясалгал, тарнийн эмчилгээг хэрэглэх эмнэлзүйн хэрэглээний чадвартай байх;
- 3.3.2.4 Анхан шатны яаралтай тусламж үзүүлэх;
- 3.3.2.5 Хэвийн төрөлт удирдах;
- 3.3.2.6 Буглаа нээх, шарханд анхдагч цэвэрлэгээ боолт хийх;
- 3.3.2.7 Эмнэлгийн анхан шатны маягт болон бусад холбогдох бичиг баримтыг стандартын дагуу хөтлөх;
- 3.3.2.8 Төвд, уйгаржин монгол бичгээр бичигдсэн ном, зохиол, хэвлэлийг мэргэжлийн түвшинд ашиглах.
- 3.3.3 “Уламжлалт анагаахын их эмч” мэргэжлээр төгсөгч нь дараах хандлага эзэмшсэн байна. Үүнд:
- 3.3.3.1 Үйлчлүүлэгч иргэд болон хамтран ажиллагсдаа нийгмийн гарал үүсэл, ёс заншил, арьс өнгө, нас, хүйсээр ялгаварлахгүй, нэр төрийг нь хүндэтгэж хандах;
- 3.3.3.2 Эмнэлгийн болон үйлчлүүлэгчийн нууцыг чанд хадгалж, өөрөө шийдвэр гаргах эрхийг хүндэтгэн хүлээн, зөвшөөрөх;
- 3.3.3.3 Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ, деонтологийн буюу үүрэг хариуцлагын дүрэм, журмыг ойлгож ухамсарласан байх.

Эрүүл мэндийн сайдын 2012 оны
04 сарын 02-ны өдрийн 102 тоот
тушаалын тавдугаар хавсралт

“Эм зүйч” мэргэжлээр бакалавр
зэрэгтэй төгсөгчид тавигдах шаардлага

1. Мэргэжлийн нэр: Эм зүйч
2. Мэргэжлийн индекс: D723400
3. Мэргэжлийн тодорхойлолт, тавигдах шаардлага

3.1 “Эм зүйч” мэргэжлийн тодорхойлолт:

Анагаах ухааны бакалаврын боловсрол эзэмшсэн эм зүйч нь төрөл бүрийн эмийн хэлбэр гарган авах, үйлдвэрлэх, шалгах арга технологийг эзэмшсэн, эмнэлзүйн тодорхой ойлголттой, хүний бие махбодид эмийн хөдлөл зүй, үйлчлэх механизм, хэрэглэх заалт, гаж нөлөөний талаар мэдлэгтэй, эм зүйн тусламж, үйлчилгээг мэргэжлийн түвшинд үзүүлэхэд шаардагдах мэдлэг, чадвар, хандлага мэргэжилтэн байна.

Төгсөгч нь онолын ба практикийн чиглэлээр судалгаа шинжилгээний ажил хийж болох ба цаашдаа төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалт, магистрантур, докторантурт суралцах эрхээр хангагдсан байна.

3.2 “Эм зүйч” мэргэжлээр төгсөгчийн бэлтгэлд тавигдах нийтлэг шаардлага. Үүнд:

3.2.1 Анагаах ухааны үндсэн салбар шинжлэх ухааны суурь онол, арга зүйг судалж, ойлгож мэдсэн, тэр хүрээнд хүн амын эрүүл мэндийг сахин хамгаалах үндсэн арга, зарчмуудыг үйл ажиллагаандаа хэрэглэж чаддаг байх;

3.2.2 Хүн амын эрүүл мэндтэй холбоотой аливаа асуудалд мэргэжлийн үүднээс бодитой хандаж, тулгамдаж буй асуудлыг шинжлэх ухаанчаар задлан шинжилж, үйл ажиллагаандаа шинжлэх ухааны үндэслэлтэй аргуудыг хэрэглэж чаддаг байх;

3.2.3 Байгаль, нийгэм, хүмүүсийн хоорондын харилцааг зохицуулдаг ёс зүй, хууль, эрх зүйн хэм хэмжээг мэддэг, сахидаг, энэ чиглэлээр тавигдах шаардлагуудыг ёсчлон биелүүлдэг, энэрэнгүй сэтгэлтэй байх;

3.2.4 Эрүүл аж төрөх ёсны талаар шинжлэх ухааны үндэслэл бүхий мэдлэгтэй байж, өөрийн бие бялдар, оюун санааг хөгжүүлэх чадвар, хандлага, дадлыг эзэмшсэн, бусад хүмүүст үлгэр дууриал үзүүлдэг байх;

3.2.5 Өөрийн үйл ажиллагаанд бодитойгоор дүн шинжилгээ хийх чадвартай, орчин үеийн мэдээллийн технологийг ашиглан, шинэ мэдлэг, мэдээлэл олж авах, бүтээлчээр ашиглах болон биеэ даан тасралтгүй суралцах чадвартай байх;

3.2.6 Мэргэжлийн ажил үүргээ биелүүлэхтэй холбогдуулан өмнөө тавигдах зорилго, зорилтуудыг оновчтой тодорхойлж, тэдгээрт хүрэх үйл ажиллагаагаа зохистой төлөвлөж чаддаг, биелүүлэхийн төлөө тууштай тэмцдэг байх;

3.2.7 Эрүүл мэндийн байгууллагын удирдлага, зохион байгуулалт, санхүүгийн менежментийн талаар зохих түвшний мэдлэгтэй байж, түүнийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлдэг байх;

3.2.8 Багаар ажиллах чадвартай, харилцааны соёл бүхий ур чадвар эзэмшсэн, өөрийгөө хүнд ойлгуулах, бусдад зөвлөгөө өгөх ур чадвартай, үйлчлүүлэгчийн санал хүсэлтийг хүндэтгэн туслах, хариуцлага хүлээх чадвартай байх;

3.2.9 Англи хэлийг өдөр тутмын болон мэргэжлийн үйл ажиллагаандаа хэрэглэх;

3.2.10 Мэдээлэл зүй, компьютерийн хэрэглээний программуудыг хэрэглэх;

3.2.11 Ажиллаж буй байгууллагын дотоод дүрэм журам, цагийн хуваарийг чанд баримтлах;

3.2.12 Өөрийн ажлын байрны тодорхойлолттой нарийн танилцаж, түүний шаардлагуудыг чандлан биелүүлэх хүсэл, зориг, эрмэлзлэлтэй байх.

3.3 Мэргэжлийн бэлтгэлд тавигдах үндсэн шаардлага

3.3.1 "Эм зүйч" мэргэжлээр төгсөгч нь дараах онолын мэдлэг эзэмшсэн байна. Үүнд:

3.3.1.1 Эмийн технологи, эмийн үйлдвэрлэл, био-инженерчлэл, биотехнологийн хэрэглээ, рекомбинант ДНА технологи, эсийн инженерчлэл;

3.3.1.2 Эм үйлдвэрлэлийн аргууд, эмийн түүхий эд ба бүтээгдэхүүний чанарын баталгаажуулалт, үйлдвэрлэлийн орчны хяналт;

3.3.1.3 Эмийн хэлбэрүүд, эмийг хэлбэршүүлэхэд хэрэглэгддэг бодисууд, эмийн хэлбэрүүдийг гарган авах зарчим;

3.3.1.4 Эмийн химийн бүтэц, холбоо, нэршил, функциональ бүлгүүд, урвалд орох чадвар, эмийн синтез, эмийн молекулын физик химийн шинж чанар, байгалийн болон синтезийн эмийн түүхий эд гарган авах эх булаг, цэвэршилт, эм зохион бүтээх туршилт судалгаа, эмийн бүтэц ба үйлчлэлийн хамаарал, эмийн стандартчилал, аюулгүй байдлын судалгааны аргууд;

3.3.1.5 Байгалийн гаралтай эмийн түүхий эд, нэршил, тархалт, үйлдэл, хэрэглээ, түүхий эдийн анхан шатны боловсруулалт, биологийн идэвхт бодисыг илрүүлэх, тоо хэмжээг тодорхойлох аргууд, байгалийн гаралтай эмийн түүхий эдийн судалгааны орчин үеийн аргууд;

- 26
- 3.3.1.6 Ургамлын эрхтэн бүтэц, үйл ажиллагаа, ургамлын аймгийн ангилал зүй, нөмрөгжилт, тарималжуулалт, ургамлын эсийн бүтэц, бүрэлдэхүүн, ялгагдах онцлог, эсэд явагдах физиологийн процесс;
 - 3.3.1.7 Уламжлалт эмийн эх сурвалж, хэлбэр дүрс, ангилал, төвд, латин нэршил, уламжлалт эмийн амт, чадал, хүч, эрдэм;
 - 3.3.1.8 Биофармаци, эмийн биологийн үйлчилгээнд нөлөөлдөг эм зүйн хүчин зүйлүүд, эмийн загварчлал, эмийн тогтвортой чанар;
 - 3.3.1.9 Эм судлал, фармакокинетик, фармакодинамик, эмийн үйлдэл, эсрэг болон харилцан нөлөө, гаж нөлөө, фармакокинетикийн загварчлал, биохүртэхүй, биоэквивалент, клиникийн хор судлал, эмийн үйлчлэлийн молекул үндэс;
 - 3.3.1.10 Эмнэлзүйн эм зүй, эмийн эмчилгээ, тунгийн дэглэм, эм хэрэглэх арга, эмийн эмчилгээний тактик, гаж нөлөөний хяналт, бүртгэл;
 - 3.3.1.11 Эм хангамжийн байгуулагуудын бүтэц, зохион байгуулалт, удирдлага, менежмент, логистик;
 - 3.3.1.12 Эмийн зах зээлийн судалгаа, сонголт, маркетингийн хяналт, судалгаа, үнэ бүрдүүлэлт, нийлүүлэлт, хадгалалт, нөөцлөлт, хөдөлгөөний асуудлууд;
 - 3.3.1.13 Эмнэлгийн бараа судлал, эмнэлгийн барааны ангилал, бүрдэл хэсэг, чанар, хадгалалт.
- 3.3.2 “Эм зүйч” мэргэжлээр төгсөгч нь дараах үр чадварыг эзэмшсэн байна. Үүнд:
- 3.3.2.1 Эм бэлдмэлийг эм зүйн технологийн дэглэмийн дагуу олон улсын болон эх орны стандартад нийцүүлэн эмийн санд ex tempore, эмийн үйлдвэрт цувралаар үйлдвэрлэх арга, технологийг эзэмшсэн байх;
 - 3.3.2.2 Эмийн түүхий эд, бүтээгдэхүүнийг лабораторид шалгах сорилт туршилтын арга, аргачлалыг эзэмшсэн байх;
 - 3.3.2.3 Орчин үеийн техник технологийг ашиглан шинэ эм бэлдмэл, оновчтой эмийн хэлбэрийг зохион бүтээх, тогтвортой байдлын судалгааг хийх аргыг эзэмших;
 - 3.3.2.4 Уламжлалт болон орчин үеийн анагаах ухааны эмийн ургамлын түүхий эдийн овог, төрлийг ялган дүйх, түүхий эдийг тарималжуулах, бэлтгэх, стандартчилах;
 - 3.3.2.5 Эмийн бүтээгдэхүүн, биологийн шингэнд химийн хортой бодисуудыг илрүүлэх хими-хор судлалын шинжилгээ хийх;
 - 3.3.2.6 Эмч, эм зүйч, эм найруулагч, иргэд, үйлчлүүлэгчдэд эмийн үйлдэл, харилцан үйлчлэл, орлуулах боломж, эмийн зохистой хэрэглээний талаар мэдээлэл, зөвлөгөө өгөх;

- 3.3.2.7 Эмийн эмчилгээтэй холбоотой гарч болох аливаа асуудлыг таньж тодорхойлох, шийдвэрлэх;
- 3.3.2.8 Эм хангамжийн байгууллагуудыг удирдах, үйл ажиллагааг төлөвлөх, дүн шинжилгээ хийх;
- 3.3.2.9 Эм хангамжийн байгууллагын бүртгэл тооцоог хөтлөх, нэгдсэн дүн гаргах, санхүүгийн тайлан балансыг үйл ажиллагаандаа ашигладаг байх;
- 3.3.2.10 Эмийн зах зээлийг судлан шилж сонгох, үнэлэлт дүгнэлт өгөх, хэрэглэгч үйлчлүүлэгчийг татах;
- 3.3.2.11 Эмтэй холбоотой хяналт, зөвшөөрлийн үйл ажиллагааг удирдах, хэрэгжүүлэх;
- 3.3.2.12 Эм бэлдмэлийг боловсруулах, гарган авах, хадгалах, түгээх, хэрэглэх бүх үе шатанд чанарын хяналтыг зохион байгуулж, баталгаажуулах;
- 3.3.2.13 Гамшиг, ослын үед эмийн хангамжийг зохион байгуулж, өвчтөн болон нэрвэгсдэд эмнэлгийн анхны тусламж үзүүлэх;
- 3.3.2.14 Эм үйлдвэрлэл, хадгалалт, түгээлт, хэрэглээнд экологи болон хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллах.
- 3.3.3 “Эм зүйч” мэргэжлээр төгсөгч нь дараах хандлага эзэмшсэн байна. Үүнд:
- 3.3.3.1 Үйлчлүүлэгч иргэд болон хамтран ажиллагсдаа нийгмийн гарал үүсэл, ёс заншил, арьс өнгө, нас, хүйсээр ялгаварлахгүй, нэр төрийг нь хүндэтгэж хандах;
- 3.3.3.2 Эмнэлгийн болон үйлчлүүлэгчийн нууцыг чанд хадгалж, өөрөө шийдвэр гаргах эрхийг хүндэтгэн хүлээн, зөвшөөрөх;
- 3.3.3.3 Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ, деонтологийн буюу үүрэг хариуцлагын дүрэм, журмыг ойлгож ухамсарласан байх.

Эрүүл мэндийн сайдын 2012 оны
04 сарын 02-ны өдрийн 102 тоот
тушаалын зургаадугаар хавсралт

**“Сувилагч” мэргэжлээр бакалаврын
зэрэгтэй төгсөгчид тавигдах шаардлага**

1. Мэргэжлийн нэр: Сувилагч
2. Мэргэжлийн индекс: D723500
3. Мэргэжлийн тодорхойлолт, тавигдах шаардлага

3.1 “Сувилагч” мэргэжлийн тодорхойлолт:

Сувилахуйн ухааны бакалаврын боловсрол эзэмшсэн сувилагч нь түгээмэл болон зонхилон тохиолдох өвчин, эмгэгүүдийн эмчилгээ оношлогоо, урьдчилан сэргийлэх тусламж, үйлчилгээнд сувилахуйн чиглэлээр анхан шатны тусламж үзүүлэх чадвартай, эрүүл мэндийн боловсрол олгох, хүн амын эрүүл мэндийг дэмжих хамгаалах чиглэлээр сувилахуйн тусламж үйлчилгээг чанартай үзүүлэхэд шаардагдах сувилахуйн ухааны онолын мэдлэг, чадвар, хандлага эзэмшсэн мэргэжилтэн байна.

Төгсөгч нь онолын ба практикийн чиглэлээр судалгаа шинжилгээний ажил хийж болох ба цаашид төрөлжсөн мэргэжлийн сургалт, магистрантур, докторантурт суралцах эрхээр хангагдсан байна.

3.2 “Сувилагч” мэргэжлээр (бакалаврын түвшинд) төгсөгчийн бэлтгэлд тавигдах нийтлэг шаардлага. Үүнд:

3.2.1 Сувилахуйн ухаан, нийгмийн эрүүл мэнд, нийгмийн шинжлэх ухааны үндсэн онолтой танилцсан, сувилахуйн үндэс суурь, үүсэл хөгжлийн талаарх мэдлэгтэй, хүн амын эрүүл мэндийг сахин хамгаалах үндсэн зарчмуудыг ойлгон үйл ажиллагаандаа хэрэглэж чаддаг байх;

3.2.2 Эрүүл мэндтэй холбогдсон аливаа асуудалд мэргэжлийн үүднээс бодитой хандаж, тулгамдаж буй асуудлыг шинжлэх ухаанчаар задлан шинжилж, үйл ажиллагаандаа шинжлэх ухааны аргуудыг хэрэглэж чаддаг байх;

3.2.3 Байгаль, нийгэм, хүмүүсийн хоорондын харилцааг зохицуулдаг ёс зүй, хууль, эрх зүйн хэм хэмжээг мэддэг, сахидаг, энэ чиглэлээр тавигдах шаардлагуудыг ёсчлон биелүүлдэг, энэрэнгүй сэтгэлтэй байх;

3.2.4 Эрүүл аж төрөх ёсны талаар шинжлэх ухааны үндэслэл бүхий мэдлэгтэй байж, өөрийн бие бялдар, оюун санааг хөгжүүлэх чадвар, дадлыг эзэмшсэн, түүгээрээ бусад хүмүүст зөв үлгэр дууриал үзүүлдэг байх;

3.2.5 Өөрийн үйл ажиллагаандаа бодитойгоор дүн шинжилгээ хийх чадвартай, орчин үеийн мэдээллийн технологийг ашиглан, шинэ мэдлэг, мэдээлэл олж авах,

түүнийгээ бүтээлчээр ашиглах болон биеэ даан тасралтгүй суралцах чадвартай байх;

3.2.6 Мэргэжлийн ажил үүргээ биелүүлэхтэй холбогдуулан, өмнөө тавигдах зорилго, зорилтуудыг оновчтой тодорхойлж, тэдгээрт хүрэх үйл ажиллагаагаа зохистой төлөвлөж чаддаг, биелүүлэхийн төлөө тууштай тэмцдэг байх;

3.2.7 Багаар ажиллах чадвартай, харилцааны ур чадвар эзэмшсэн, өөрийгөө хүнд ойлгуулах, зөвлөгөө өгөх ур чадвартай, үйлчлүүлэгчийн санал хүсэлтийг хүндэтгэн, туслах, хариуцлага хүлээх чадвартай байх;

3.2.8 Англи хэлийг өдөр тутмын болон мэргэжлийн үйл ажиллагаандаа хэрэглэх;

3.2.9 Мэдээлэл зүй, компьютерийн хэрэглээний программуудыг хэрэглэх;

3.2.10 Эрүүл мэндийн анхан шатны байгууллагын удирдлага, зохион байгуулалт, санхүүгийн менежментийн талаар зохих түвшний мэдлэгтэй байж, түүнийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлдэг байх;

3.2.11 Ажиллаж буй байгууллагынхаа дотоод дүрэм, журам, цагийн хуваарийг чанд баримтлах;

3.2.12 Өөрийн ажлын байрны тодорхойлолттой нарийн танилцаж, түүний шаардлагуудыг чандлан биелүүлэх хүсэл, зориг, эрмэлзлэлтэй байх.

3.2 Сувилахуйн мэргэжлээр (бакалаврын түвшинд) төгсөгчийн бэлтгэлд тавигдах үндсэн шаардлага.

3.3.1. “Сувилагч” мэргэжлээр төгсөгч нь дараах онолын мэдлэг эзэмшсэн байна. Үүнд:

3.3.1.1. Хүний биеийн эрхтэн, тогтолцооны өвчин эмгэгийн үед үзүүлэх сувилгааны мөн чанар, өвчин үүссэн шалтгаан эмгэг жам, үе шат, явц сувилахуйн тусламж үйлчилгээний талаар орчин үеийн сувилахуйн шинжлэх ухааны суурь мэдлэг;

3.3.1.2. Төрөлжсөн болон түгээмэл үйлдлийн стандарт, аюулгүй тарилга, халдвар хамгааллын дэглэм, ариутгал, халдваргүйжүүлгийн талаарх мэдлэг;

3.3.1.3. Халдвар, хамгаалал, аюулгүй ажиллагааны талаарх мэдлэг;

3.3.1.4. Амьсгалын замын эрхтэн тогтолцооны эмгэгийн үед үзүүлэх сувилахуйн тусламж үйлчилгээ, сувилахуйн хяналт;

3.3.1.5. Зүрх судасны эрхтэн тогтолцооны эмгэгийн үед үзүүлэх сувилахуйн тусламж үйлчилгээ, сувилахуйн хяналт;

3.3.1.6. Шээс ялгаруулах эрхтэн тогтолцооны эмгэгийн үед үзүүлэх сувилахуйн тусламж үйлчилгээ, сувилахуйн хяналт;

- 3.3.1.7. Хоол боловсруулах эрхтэн тогтолцооны эмгэгийн үед үзүүлэх сувилахуйн тусламж үйлчилгээ, сувилахуйн хяналт;
- 3.3.1.8. Мэс заслын сувилахуйн суурь тусламж үйлчилгээ, сувилахуйн хяналт;
- 3.3.1.9. Хорт хавдрын өвөрмөц эмчилгээний үеийн сувилахуйн тусламж, сувилахуйн хяналт;
- 3.3.1.10. Насны ангиллын онцлогоос шалтгаалсан сувилахуйн тусламж үйлчилгээ, сувилахуйн хяналт;
- 3.3.1.11. Сэтгэцийн эмгэгтэй хүмүүст үзүүлэх сувилахуйн тусламж, үйлчилгээ, сувилахуйн хяналт;
- 3.3.1.12. Гэмтэл бэртлийн үеийн сувилахуйн тусламж үйлчилгээ, сувилахуйн хяналт;
- 3.3.1.13. Халдварт өвчний үеийн халдвар хамгааллын дэглэм;
- 3.3.1.14. Сувилахуйн удирдлага, зохион байгуулалт.

3.3.2. “Сувилагч” мэргэжлээр төгсөгч нь дараах үр чадварыг эзэмшсэн байна. Үүнд:

- 3.3.2.1. Сувилахуйн тусламж үйлчилгээг тасаг, нэгжийн түвшинд удирдан зохион байгуулах;
- 3.3.2.2. Дипломын боловсролтой сувилагч болон туслах сувилагчийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;
- 3.3.2.3. Шинэ сувилагч, туслах сувилагч зэрэг бусад сувилагч нарт мэргэжлийн арга зүйн зөвлөмж өгөх;
- 3.3.2.4. Сувилахуйн үйл ажиллагааны таван шатлалыг мөрдөх, үйл ажиллагаандаа хэвшүүлэх;
- 3.3.2.5. Сувилахуйн анхан шатны бичиг баримт, эмийн хуудас, эмийн тооцоог хөтлөх, шинэ сувилагч, туслах сувилагч зэрэг бусад сувилагч нарт энэ чиглэлээр зөвлөгөө, заавар өгөх;
- 3.3.2.6. Эмнэлгийн тоног төхөөрөмж, багаж материалын ашиглалт болон аюулгүй ажиллагааны горимыг мөрдөж ажиллах;
- 3.3.2.7. Халдвар хамгаалал, аюулгүй ажиллагааг баримтлах;
- 3.3.2.8. Сувилахуйн түгээмэл үйлдлийн стандарт, эмнэл зүйн удирдамжийг хэрэгжүүлэх, хянах;
- 3.3.2.9. Үйлчлүүлэгчдэд тулгамдаж буй асуудлыг нотолгоонд тулгуурлан судлах, үнэлэх, дүн шинжилгээ хийх;

3.3.2.10. Зонхилон тохиолдох өвчин эмгэгийн үед үзүүлэх сувилахуйн тусламж үйлчилгээг цогцоор нь үзүүлэх;

3.3.2.11. Дараах гардан үйлдлийг хийж чаддаг байх, шинэ сувилагч, туслах сувилагч зэрэг бусад сувилагч нарт зааж, сургах:

3.3.2.11.1. Ор засах (бүх төрөл);

3.3.2.11.2. Бүх биеийн ба хэсэгчилсэн угаалга хийх;

3.3.2.11.3. Амин үзүүлэлт үзэх, хэмжих;

3.3.2.11.4. Өндөр, жин үзэх;

3.3.2.11.5. Арьс, булчин, хураагуур судсанд тариа хийх;

3.3.2.11.6. Цусны бүлэг тодорхойлох, цус сэлбэхэд хувийн болон биологийн тохироо үзэх;

3.3.2.11.7. Шээлгүүр тавих;

3.3.2.11.8. Ходоод угаах;

3.3.2.11.9. Давсаг угаах;

3.3.2.11.10. Бургуй тавих;

3.3.2.11.11. Эмийн бус эмчилгээний арга засал хийх г.м;

3.3.2.11.12. Бүх төрлийн шинжилгээнд бэлтгэх, шаардлагатай шинжилгээ авах.

3.3.3. “Сувилагч” мэргэжлээр төгсөгч нь дараах хандлага эзэмшсэн байна. Үүнд:

3.3.3.1 Үйлчлүүлэгч иргэд болон хамтран ажиллагсдаа нийгмийн гарал үүсэл, ёс заншил, арьс өнгө, нас, хүйсээр ялгаварлахгүй, нэр төрийг нь хүндэтгэж хандах;

3.3.3.2 Эмнэлгийн болон үйлчлүүлэгчийн нууцыг чанд хадгалж, өөрөө шийдвэр гаргах эрхийг хүндэтгэн хүлээн, зөвшөөрөх;

3.3.3.3 Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ, деонтологийн буюу үүрэг хариуцлагын дүрэм, журмыг ойлгож ухамсарласан байх.

Эрүүл мэндийн сайдын 2012 оны
04 сарын 02 -ны өдрийн 102 тоот
тушаалын долоодугаар хавсралт

“Сувилагч” мэргэжлээр дипломын
зэрэгтэй төгсөгчид тавигдах шаардлага

1. Мэргэжлийн нэр: Сувилагч
2. Мэргэжлийн индекс: 723500
3. Мэргэжлийн тодорхойлолт, тавигдах шаардлага

3.1 “Сувилагч” мэргэжлийн тодорхойлолт:

Сувилахуйн ухааны дипломын боловсрол эзэмшсэн сувилагч нь энэрэн асрахуйн сэтгэлтэй, ёс зүйг эрхэмлэгч, иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох, хүн амын эрүүл мэндийг дэмжих хамгаалах, үйлчлүүлэгчийн нууцыг хадгалах, хүний амь насыг хариуцан ажиллах, сувилгааны анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлэх мэдлэг, чадвар, хандлагатай мэргэжилтэн байна.

Төгсөгч нь онолын ба практикийн чиглэлээр судалгаа шинжилгээний ажил хийж болох ба цаашдаа бакалаврын сургалтанд шатлан суралцах болон төрөлжсөн мэргэжлийн сургалтанд суралцах эрхээр хангагдсан байна.

3.2 Сувилагч мэргэжлээр (дипломын түвшинд) төгсөгчийн бэлтгэлд тавигдах нийтлэг шаардлага. Үүнд:

3.2.1 Сувилахуйн ухаан, нийгмийн эрүүл мэнд, нийгмийн шинжлэх ухааны үндсэн онолтой танилцсан, сувилахуйн үндэс суурь, үүсэл хөгжлийн талаарх мэдлэгтэй, хүн амын эрүүл мэндийг сахин хамгаалах үндсэн зарчмуудыг ойлгон үйл ажиллагаандаа хэрэглэж чаддаг байх;

3.2.2 Эрүүл мэндтэй холбогдсон аливаа асуудалд мэргэжлийн үүднээс бодитой хандаж, тулгамдаж буй асуудлыг шинжлэх ухаанчаар задлан шинжилж, үйл ажиллагаандаа шинжлэх ухааны аргуудыг хэрэглэж чаддаг байх;

3.2.3 Байгаль, нийгэм, хүмүүсийн хоорондын харилцааг зохицуулдаг ёс зүй, хууль, эрх зүйн хэм хэмжээг мэддэг, сахидаг, энэ чиглэлээр тавигдах шаардлагуудыг ёсчлон биелүүлдэг, энэрэнгүй сэтгэлтэй байх;

3.2.4 Эрүүл аж төрөх ёсны талаар шинжлэх ухааны үндэслэл бүхий мэдлэгтэй байж, өөрийн бие бялдар, оюун санааг хөгжүүлэх чадвар, дадлыг эзэмшсэн, түүгээрээ бусад хүмүүст зөв үлгэр дууриал үзүүлдэг байх;

3.2.5 Өөрийн үйл ажиллагаандаа бодитойгоор дүн шинжилгээ хийх чадвартай, орчин үеийн мэдээллийн технологийг ашиглан, шинэ мэдлэг, мэдээлэл олж авах, түүнийгээ бүтээлчээр ашиглах болон биеэ даан тасралтгүй суралцах чадвартай байх;

3.2.6 Мэргэжлийн ажил үүргээ биелүүлэхтэй холбогдуулан, өмнөө тавигдах зорилго, зорилтуудыг оновчтой тодорхойлж, тэдгээрт хүрэх үйл ажиллагаагаа зохистой төлөвлөж чаддаг, биелүүлэхийн төлөө тууштай тэмцдэг байх;

3.2.7 Багаар ажиллах чадвартай, харилцааны ур чадвар эзэмшсэн, өөрийгөө хүнд ойлгуулах, зөвлөгөө өгөх ур чадвартай, үйлчлүүлэгчийн санал хүсэлтийг хүндэтгэн, туслах, хариуцлага хүлээх чадвартай байх;

3.2.8 Англи хэлийг өдөр тутмын болон мэргэжлийн үйл ажиллагаандаа хэрэглэх;

3.2.9 Мэдээлэл зүй, компьютерийн хэрэглээний программуудыг хэрэглэх;

3.2.10 Эрүүл мэндийн анхан шатны байгууллагын удирдлага, зохион байгуулалт, санхүүгийн менежментийн талаар зохих түвшний мэдлэгтэй байж, түүнийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлдэг байх;

3.2.11 Ажиллаж буй байгууллагынхаа дотоод дүрэм, журам, цагийн хуваарийг чанд баримтлах;

3.2.12 Өөрийн ажлын байрны тодорхойлолттой нарийн танилцаж, түүний шаардлагуудыг чандлан биелүүлэх хүсэл, зориг, эрмэлзлэлтэй байх.

3.2 “Сувилагч” мэргэжлээр (дипломын түвшинд) төгсөгчийн бэлтгэлд тавигдах үндсэн шаардлага

3.3.1 Сувилагч мэргэжлээр төгсөгч нь дараах онолын мэдлэг эзэмшсэн байна. Үүнд:

3.3.1.1 Хүний биеийн эрхтэн, тогтолцооны өвчин эмгэгийн үед үзүүлэх сувилахуйн тусламж үйлчилгээний талаарх орчин үеийн сувилахуйн шинжлэх ухааны суурь мэдлэг;

3.3.1.2 Амьсгалын замын эрхтэн тогтолцооны эмгэгийн үед үзүүлэх сувилахуйн тусламж үйлчилгээ, сувилахуйн хяналт;

3.3.1.3 Зүрх судасны эрхтэн тогтолцооны эмгэгийн үед үзүүлэх сувилахуйн тусламж үйлчилгээ, сувилахуйн хяналт;

3.3.1.4 Шээс ялгаруулах эрхтэн тогтолцооны эмгэгийн үед үзүүлэх сувилахуйн тусламж үйлчилгээ, сувилахуйн хяналт;

3.3.1.5 Хоол боловсруулах эрхтэн тогтолцооны эмгэгийн үед үзүүлэх сувилахуйн тусламж үйлчилгээ, сувилахуйн хяналт;

3.3.1.6 Мэс заслын сувилахуйн суурь тусламж үйлчилгээ, сувилахуйн хяналт;

3.3.1.7 Хорт хавдрын өвөрмөц эмчилгээний үеийн сувилахуйн тусламж, үйлчилгээ, сувилахуйн хяналт;

3.3.1.8 Насны ангиллын онцлогоос шалтгаалсан эмгэгийн үеийн сувилахуйн тусламж үйлчилгээ, сувилахуйн хяналт;

3.3.1.9 Сэтгэцийн эмгэгтэй хүмүүст үзүүлэх сувилахуйн тусламж, үйлчилгээ, сувилахуйн хяналт, сувилахуйн хяналт;

3.3.1.10 Гэмтэл бэртлийн үеийн сувилахуйн тусламж үйлчилгээ, сувилахуйн хяналт;

3.3.1.11 Халдварт өвчний үеийн халдвар хамгаалаллын дэглэм.

3.3.2 “Сувилагч” мэргэжлээр төгсөгч нь дараах үр чадварыг эзэмшсэн байна. Үүнд:

3.3.2.1. Сувилахуйн үйл ажиллагааны таван шатлалыг мөрдөх, үйл ажиллагаандаа хэвшүүлэх;

3.3.2.2. Сувилахуйн анхан шатны бичиг баримт, эмийн хуудас, эмийн тооцоог хөтлөх;

3.3.2.3. Эмнэлгийн тоног төхөөрөмж, багаж материалын ашиглалт болон аюулгүй ажиллагааны талаар мэдлэгтэй байх;

3.3.2.4. Халдвар хамгаалал, аюулгүй ажиллагааг баримтлах;

3.3.2.5. Сувилахуйн түгээмэл үйлдлийн стандартыг хэрэгжүүлэх, хянах;

3.3.2.6. Үйлчлүүлэгчдэд тулгамдаж буй асуудлыг нотолгоонд тулгуурлан судлах, үнэлэх, дүн шинжилгээ хийх;

3.3.2.7. Дараах сувилахуйн гардан ажилбаруудыг мэргэжлийн түвшинд хийж, туслах сувилагчид зааж сургах:

3.3.2.7.1. Ор засах (бүх төрөл);

3.3.2.7.2. Бүх биеийн ба хэсэгчилсэн угаалга хийх;

3.3.2.7.3. Амин үзүүлэлт үзэх, хэмжих;

3.3.2.7.4. Өндөр, жин үзэх;

3.3.2.7.5. Арьс, булчин, хураагуур судсанд тариа хийх;

3.3.2.7.6. Цусны бүлэг тодорхойлох, цус сэлбэхэд хувийн болон биологийн тохироо үзэх;

3.3.2.7.7. Шээлгүүр тавих;

3.3.2.7.8. Ходоод угаах;

3.3.2.7.9. Давсаг угаах;

3.3.2.7.10. Бургуй тавих;

3.3.2.7.11. Эмийн бус эмчилгээний арга засал хийх г.м;

3.3.2.7.12. Бүх төрлийн шинжилгээнд бэлтгэх, шаардлагатай шинжилгээ авах.

3.3.2 “Сувилагч” мэргэжлээр төгсөгч нь дараах хандлага эзэмшсэн байна. Үүнд:

- 3.3.3.1 Үйлчлүүлэгч иргэд болон хамтран ажиллагсдаа нийгмийн гарал үүсэл, ёс заншил, арьс өнгө, нас, хүйсээр ялгаварлахгүй, нэр төрийг нь хүндэтгэж хандах;
- 3.3.3.2 Эмнэлгийн болон үйлчлүүлэгчийн нууцыг чанд хадгалж, өөрөө шийдвэр гаргах эрхийг хүндэтгэн хүлээн, зөвшөөрөх;
- 3.3.3.3 Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ, деонтологийн буюу үүрэг хариуцлагын дүрэм, журмыг ойлгож ухамсарласан байх.

Эрүүл мэндийн сайдын 2012 оны
0.11 сарын 02-ны өдрийн 102 тоот
тушаалын наймдугаар хавсралт

“Туслах сувилагч” мэргэжлээр
төгсөгчид тавигдах шаардлага

1. Мэргэжлийн нэр: Туслах сувилагч
2. Мэргэжлийн индекс: 7235000
3. Мэргэжлийн тодорхойлолт, тавигдах шаардлага

3.1 “Туслах сувилагч” мэргэжлийн тодорхойлолт:

Туслах сувилагч нь эрүүл ба өвчтэй хүмүүсийн амьдралын чанарыг сайжруулах зорилгоор тайван тохилог орчин, зохистой хооллолт, хөдөлгөөн зэрэг хүний амьдралын наад захын нөхцөлийг бүрдүүлэх, шинжлэх ухааны үндэстэй асаргаа, сувилгааг бүх төрлийн эмнэлэг, асрамжийн газарт болон гэрээр үзүүлэх чадвартай мэргэжилтэн байна.

Туслах сувилагчаар төгсөгч нь цаашид сувилахуйн мэргэжлээр шатлан суралцах эрхээр хангагдсан байна.

3.2 Туслах сувилагч мэргэжлээр төгсөгчийн бэлтгэлд тавигдах нийтлэг шаардлага. Үүнд:

3.2.1 Сувилахуйн ухаан, нийгмийн эрүүл мэнд, нийгмийн шинжлэх ухааны үндсэн онолтой танилцсан, хүн амын эрүүл мэндийг сахин хамгаалах үндсэн зарчмуудыг ойлгон үйл ажиллагаандаа хэрэглэж чаддаг байх;

3.2.2 Байгаль, нийгэм, хүмүүсийн хоорондын харилцааг зохицуулдаг ёс зүй, хууль, эрх зүйн хэм хэмжээг мэддэг, сахидаг, энэ чиглэлээр тавигдах шаардлагуудыг ёсчлон биелүүлдэг, энэрэнгүй сэтгэлтэй байх;

3.2.3 Эрүүл аж төрөх ёсны талаар шинжлэх ухааны үндэслэл бүхий мэдлэгтэй байж, өөрийн бие бялдар, оюун санааг хөгжүүлэх чадвар, дадлыг эзэмшсэн, бусад хүмүүст үлгэр дууриал үзүүлдэг байх;

3.2.4 Өөрийн үйл ажиллагаанд бодитойгоор дүн шинжилгээ хийх чадвартай, орчин үеийн мэдээллийн технологийг ашиглан, шинэ мэдлэг, мэдээлэл олж авах, бүтээлчээр ашиглах болон бие даан тасралтгүй суралцах чадвартай байх;

3.2.5 Багаар ажиллах чадвартай, харилцааны ур чадвар эзэмшсэн, өөрийгөө хүнд ойлгуулах, зөвлөгөө өгөх чадвартай, үйлчлүүлэгчийн санал хүсэлтийг хүндэтгэн, туслах, хариуцлага хүлээх чадвартай байх;

3.2.7 Англи хэлний зохих мэдлэгтэй байх;

3.2.7 Мэдээлэл зүй, компьютерийн хэрэглээний программуудыг зохих түвшинд хэрэглэх чадвартай байх;

3.2.8 Ажиллаж буй байгууллагынхаа дотоод дүрэм, журам, цагийн хуваарийг чанд баримтлах;

3.2.8 Өөрийн ажлын байрны тодорхойлолттой нарийн танилцаж, түүний шаардлагуудыг чандлан биелүүлэх хүсэл, зориг, эрмэлзлэлтэй байх.

3.3 Туслах сувилагчаар төгсөгчийн бэлтгэлд тавигдах үндсэн шаардлага.

3.3.1 Туслах сувилагч мэргэжлээр төгсөгч нь дараах онолын мэдлэг эзэмшсэн байна. Үүнд:

3.3.1.1 Хүний эрүүл мэндийн тухай болон эрүүл ахуйн талаарх суурь ойлголт, эрүүл байхын үндсэн нөхцлүүд, түүнд нөлөөлөх хүчин зүйлс;

3.3.1.2 Хүний нас, хүйснээс хамаарсан асаргаа, сувилгааны өвөрмөц, онцлогууд;

3.3.1.3 Өвчний эхлэл, хамшинж, эмгэг байдлын талаар зохих мэдлэгтэй байх;

3.3.1.4 Нийгмийн эрүүл мэндийн суурь мэдлэгтэй, түүний практикийн ач холбогдлын талаарх ойлголт;

3.3.1.5 Өвчтөнд үзүүлэх урт, богино хугацааны түгээмэл асаргааны үндсэн зарчим, туслах сувилагчийн үүрэг;

3.3.1.6 Үйлчлүүлэгчийн үзлэгийн карт, эмнэлгийн түүхийн талаарх мэдлэг;

3.3.1.8 Ярианы болон бичгийн харилцааны ач холбогдол, харилцааны бэрхшээлийн талаарх ойлголт.

3.3.2 Туслах сувилагч мэргэжлээр төгсөгч нь дараах үр чадварыг эзэмшсэн байна. Үүнд:

3.3.2.1 Үйлчлүүлэгчийн зовиур шаналгааг асуух, харах, хүрэлцэх аргаар тодорхойлж, шаардлагатай асаргаа, сувилгаа хийх;

3.3.2.2 Өвчтөнг усанд оруулах, хувцаслах, хувийн ариун цэвэр сахих, хөдөлгөөнд дэмжлэг үзүүлэх;

3.3.2.3 Шинжилгээний дээжийг цуглуулах, шинжилгээнд өвчтөн бэлтгэх;

3.3.2.4 Хооллолтын зөвлөгөө өгөх, хооллолтын байдалд хяналт тавих;

3.3.2.5 Өвчтөнд хийгдэж байгаа эмчилгээг хянах арга барил эзэмших;

3.3.2.6 Өвчтөн, түүний асран хамгаалагчдад зарим асаргаа сувилгааг заах;

3.3.2.7 Асаргаа, сувилгаанд шаардлагатай зарим тоног төхөөрөмж, багаж хэрэгслэлийг ашиглах, цэвэрлэгээ үйлчилгээг хийх.

3.3.4 Туслах сувилагч мэргэжлээр төгсөгч нь дараах хандлага эзэмшсэн байна.
Үүнд:

3.3.3.1 Үйлчлүүлэгч иргэд болон хамтран ажиллагсдаа нийгмийн гарал үүсэл, ёс заншил, арьс өнгө, нас, хүйсээр ялгаварлахгүй, нэр төрийг нь хүндэтгэж хандах;

3.3.3.2 Эмнэлгийн болон үйлчлүүлэгчийн нууцыг чанд хадгалж, өөрөө шийдвэр гаргах эрхийг хүндэтгэн хүлээн, зөвшөөрөх;

3.3.3.3 Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ, деонтологийн буюу үүрэг хариуцлагын дүрэм, журмыг ойлгож ухамсарласан байх.

.....ooOoo.....